

НЭГЭН МАНЖ ДАНСААС ХVII-ХVIII ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЫН ХУДАЛДААЧНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Чимэдийн УЛААНБАРС

Товч агуулга: Тус өгүүлэлд Өвөр Монголын Алшаа зүүн хошууны дансны газарт хадгалагдаж байгаа нэгэн хувь манж дансийн агуулгыг задлан шинжихээр дэмжиж 17-р зууны дундаж үеэс 18-р зууны эхэн үе хүртэлх Хөхнуур хошууд монголын ноёны доорх нэгэн муслим худалдаачны явсан зам мөр ба худалдаачны байдлыг элчилж бас тухайн үеийн монголын Халх Ойрадын төрийн дотоод дахь харьцаа жич Халх Ойрадын төр болон Дайчин гүрэн, Цагаан хаант Орос, Осман Түркийн хаант улс, Энэтхэг Моголын хаант улсын хоорон дахь худалдааны байдлыг тодорхойлон тухайн үеийн Монгол орнуудын арилжаа худалдаа эрхлэх онцлог ба ази европын олон улсын хоорон дахь харилцаа холбоог авч үзнэ.

Түлхүүр үг: Алшаа зүүн хошууны данс, муслим худалдаачин Далай бэг, Хөхнуур, Их шавь, эзэн харьяатын харилцаа.

Оршил

2007 оны 8-р сард, миний бие Өвөр Монголын Өөртөө Засах Орны Алшаа аймгийн Алшаа зүүн хошууны дансны газраас нэгэн хувь манж данс олов. Энэхүү манж дансанд их төлөв ХVII зууны дундаас ХVIII зууны эхний үеийг хүртэлх Хөхнуурын хошууд монгол ноёны доорх нэгэн муслим худалдаачин олон газраар хэрэн явж худалдаа хийж байсан тухай тэмдэглэжээ. Тус дансны бүртгэлийн дугаар нь Хөмрөг 101, Данс 3 бөгөөд нийт 8 хуудас болно. Дансны эхний нүүрэнд тус дансын газраас, “Хотон Далай бэг хэмээгч угтаа хэрхэн Эфүгийн харьяат болсон ба магадтэмдгийг тодорхойлон гаргаж мэдүүлээр ирүүлсүгэй хэмээсэн Их журганы бичиг” хэмээх гарчиг хаджээ.

Манж галиг

tulergi golo be dasar jurgan i bithe. /ület i giyün wang bihe efu aboo i gūsade unggihe./ jebdzundamba kūtuku i kuren i baita be icihiyara erdeni šanjotba dorji wangcuk i / alibume benjihe bithede ület i doroi giyün wang/ hošoi efu aboo i alibume benjihe/ bithede mini mukün i huhu noor i harangga mergen daicin / erincin i beye nimefi boihon muke de acarakū/ turgunde meni harangga ba i kundulen bira i bade jifi tehe bihe. amala ini bade gurifi/ genembi seme huhu noor i bade genere fonde/ mergen daicin erincin meni mmonggo niyalma be/ juwan dahalabufi kalkai bade hūdašame unggihe./ tere hoide dahalabuha juwan niyalma be/ suwe te amasi gene bi ubade udu / aniya teme hūdašame

yabuki seme alafi / tehe bihe. mergen daicin erincin huhu/ noor de genere de ere hoise be/ lehome gaime jabduhakū. be hanci mukūn i / ahūn deo ofi mimbe si tere hoise be/ lehome gaisu sehe bihe. amala ere / hoise be lehome gaiki seci hūdašame / fulu bahakini seme gaihakū. te jebdzundamba / kūtuktu i šabisai sasa tehe be / donjifi ere hoise yabuhai baita/ tucire be boljoci ojarahū seme gūnifi/ hoise i turgun be neneme jebdzundamba/ kūtuktu šanjotba de alaha de/ šanjotba i gisun ere hoise neneme ejen/ akū hoise seme alafi meni šabisai sasa/ tehebi. aika ere gese turgun baci / suwe gaisu sehe bihe. tuttu bicibe/ amba jurgan de turgun be boolarakū / oci icihiyame banjinarakū ofi te amba/ jurgan ci joriha songkoi dahame yabuki sehebi./ uttu ofi baicaci efu aboo i alibuha/ bade udu ini harangga dalai bek be/ ne jebdzundamba kūtuktu i šabisai sasa/ tehebi. šanjotba i baci erebe gaikini / secibe damu hoise dalai bek neneme/ adarame kūtuktu i šabisai sasa tehe. / te tubade bisire akū. jai encu turgun / bisire akū babe šanjotba de baicanarakū/ uthai toktobume banjinarakū be dahame / er- ebe suweni baci dalai bek ne bisire / akū daci adarame tubade tehe jai/ encu turgun bisire akū babe baicafi/ boolanjikini. boolanjiha erinde jai gisureki. / erei jalin unggihe sehebi. uttu ofi / baicaci ere dalai bek sere hoise meni/ šsasa tehe- bi. neneme doroi giyūn/ wang hošoi efu aboo dalai bek be/ jondoho turgunde mini henduhe bade dalai/ bek meni šabisai sasa tehebi seheci tulgiyen / suwe gaisu sehe ba akū. te dalai / bek i alaha bade bi serengge ūlet i / hoise waka. mini giranggi da xiyang sere/ hoise bihe. juwan duin se de sefu be / dahame oros i cagan han i bade isinafi/ tubade yabuha. amala kemuni baksi be/ dahame hūdašame kungker han gasalbasi han i / bade isinafi hūdašame kungker han gasalbasi han i / bade isinafi sunja ninggun aniya goidame/ tere jakade mini sefu bucehe. tereci bi / kemuni enetkek i ocir tu bade isinafi/ geli sunja ninggun aniya hūdašame tehe. / amala tubet i bade jifi dalai lama de / hengkilefi tubet i bade hūdašame yabuha. / amala huhu noor si ning be darime/ hūdašame yabuhai šangnan dorji lama hiya/ ananda hiya kesitu sede acafi cende yabuha / ele tur- gun be gemu alafi tereci ging hecen de/ dosifi hūdašame tehe. amala geli amasi/ enetkek i bade genefi hūdašame yabufi / dasame hami turfan i bade bederefi/ hūdašame tehe. elhe taifin i dehi ningguci/ aniya kemuni jebdzundamba kūtuk- tu i kuren de/ jifi kūtuktu de hengkileme babade hergime/ yabuha turgun be gemu kūtuktu de / donjifi ere bade nikefi šabi ome/ hūdašame ekisaka dehei. tetele tehe/ turgun ere. bi daci babade hergide mini / cihai hūdašame yabuhaci tulgiyen uma emu/ bade goidame tefi emu niyalma be ejen / seme yabuha ba akū sembi. ere dalai / bek serengge daci enetkek balbu tubet/ oros i jergi bade hergime yabume ejen/ akū cihai hūdašame yabuha niyalma. te/ ini alaha bade ere jergi turgun bihe / sehebe dahame ere baita be adarame obure be amba jurgan ci joriha be/ tuwame dahame yabuki sehebi. baicaci neneme / efu aboo

i baci ini yabuki sehebi. baicaci neneme/ efu aboo i baci ini harangga hoise dalai / bek be ne jebdzundamba kūtuktu i / šabinar i emgi tehebi jurgan ci adarame/ obure babe tokto bureo seme alibume benjihede/ musei jurgan ci hoise dalai bek daci / adarame šabinar i emgi tehe ne tubade / bisire akū babe baicafi bool-anjikini seme/ šangjotba de baicaname bithe unggihe be / dangsede ejehebi. / te šangjotba i baci / baicafi alibuha bade dalai bek serengge / daci enetkek balbu tubet oros i jergi / bade hūdašame yabure niyalma umai ulet i / hoise waka be dahame adarame obure / babe jurgan ci jorireo sehebi. dalai bek / eici efu aboo i harangga hoise inu waka / babe getukeleme baicarakū oci tokto bume / gisureci ojurakube dahame erebe efu / bihe aboo i gūsade bithe unggifi/ hoise dalai bek da adarame efu [зай авсан] / harangga oho yargiyan temgetu be getukeleme / tucibume boolanjikini. isinjiha erinde jai / gisureki. erei jalin unggihe./ abkai wehiyehe i duici aniya juwan biyai orin jakūn. /

Монгол орчуулга

Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яамны бичиг. Өөлдийн жүн ван байсан эфү Абуугийн хошуунд илгээв. Жавзандамба хутагтын хүрээний хэргийг шийтгэх Эрдэнэ шанзудба Доржванчигийн өргөн барьж хүргэн ирсэн бичигт, Журганаас надад Өөлдийн төрийн жүн ван эфү Абуугийн өргөн барихаар хүргэн ирсэн бичигт, миний төрлийн Хөх нуурын харьяат Мэргэн дайчин Эринчиний бие нь өвчилж шороо усанд таарахгүйн учирт манай харьяат газрын Хөндлөн голын газарт ирж суусан билээ. Хойно түүний газарт шилжиж очмуу хэмээн Хөхнуурын газарт очихдоо Мэргэн дайчин Эринчин миний харьяат Далай бэг хэмээх хотонг манай монгол хүнийг арав дагуулж халхын газарт худалдаа хийлгэхээр илгээв.

Тэр хотон дагуулсан арван хүнд, “Та нар эдүгээ хойш од. Би энд хэдэн жил сууж худалдаа хийж явья” хэмээн холдож суусан байв. Мэргэн дайчин Рэнчин Хөхнуурт очихдоо энэ хотонг хоморголж авч завдсангүй, бид ойр төрлийн ахан дүү тул надыг чи тэр хотонг хоморголж ав хэмээсэн байв. Хойно энэ хотонг хоморголж авья хэмээвээс, худалдаа хийж илүүхэн олгуулья хэмээн авсангүй. Эдүгээ Жавзундамба хутагтын шавь нартай хамт суусныг сонсч, энэ хотон явсаар хэрэг гаргахыг болзвоос болохгүй хэмээн санаж хотонгийн учрыг урьд Жавзандамба хутагтын Шанзудбад хэлсэнд Шанзудбагийн үг, “Энэ хотонг урьд эзэнгүй хотон хэмээн хэлж манай шавь нартай хамт суусан буй. Хэрвээ энэ мэт учир байваас та нар ав” хэмээсэн байв. Тийм болбоос Их журганд учрыг мэдүүлэхгүй болбоос шийтгэж болохгүй тул эдүгээ Их журганд учрыг мэдүүлэв. Их журганаас заасан ёсоор дагаж явья хэмээсэн буй. Иймийн тул байцааваас, эфү Абуугийн өргөн барьсан газарт хэдүй түүний харьяат Далай бэгийг эдүгээ Жавзандамба хутагтын шавь нартай хамт суусан буй. Шанзудбын газраас үүнийг авхуулья хэмээвч ганц хотон Далай бэгийг урьд хэрхэн хутагтын шавь нартай хамт

суусан, эдүгээ тэнд байх эсэх, бас ямар учраас байх үгүй газрыг Шанзудбагаас очиж байцаахгүй бол даруй тогтоож болохгүй тул үүнийг таны газраас Далай бэг эдүгээ байх эсэх, угтаа хэрхэн тэнд суув, бас өөр учир байх эсэх газрыг байцааж мэдүүлэн ирүүлье. Мэдүүлэн ирсэн цагт дахин хэлэлцье. Үүний тул илгээв хэмээсэн буй. Иймийн тул байцааваас, энэ Далай бэг хэмээх хотон манай шавь нартай хамт суусан буй. Урьд төрийн жүн ван хошой эфү Абуу Далай бэгийг дурдсан учирт миний өгүүлсэн газарт, Далай бэг манай шавь нартай хамт суусан буй хэмээснээс гадна та ав хэмээсэн газар үгүй. Эдүгээ Далай бэгийн хэлсэн газарт, Би хэмээгч Өөлдийн хотон биш. Миний яс Да сиан хэмээх хотон билээ. Арван дөрвөн настайд багшийг дагаж Оросын цагаан хааны газарт хүрэн одож тэнд явав. Хойно басхүү багшийг дагаж худалдаагаар Хүнхэр хаан, Гасалбаш хааны газарт хүрэн одож худалдаа хийж явав. Хойно Энэтхэгийн газарт хүрэн одож тав, зургаан жил үргэлжлэн суух дэргэд минь багш үхэв. Түүнээс би басхүү Энэтхэгийн очирт газарт хүрэн одож бас тав, зургаан жил худалдаа хийж суув. Хойно Түвдийн газарт ирж Далай ламд мөргөж, Түвдийн газарт худалдаа хийж явсны хойно Хөх нуур, Шининг дайран худалдаа хийж явсаар Шаннандорж лам, хиа Ананд, хиа Хэшт нартай золгож тэдгээрт явсан эл учрыг цөм хэлж, түүнээс Нийслэл хотонд орж худалдаа хийж суув. Хожим бас хойш Энэтхэгийн газарт очиж худалдаагаар явж, дахиж Хами, Турфаны газарт эгж худалдаа хийж суув. Энх-Амгалангийн дөчин зургадугаар он басхүү Жавзандамба хутагтын хүрээнд ирж хутагтад мөргөж, газар газарт хэрэн явсан учрыг хутагтад сонсгож, энэ газарт түшиж шавь болж, худалдаа хийж дув дуугүй суусаар эдүгээ болтол суусан учир энэ. Би угаас газар газарт хэрж, миний дураар худалдаа хийж явснаас гадна огт нэг газарт удаан сууж нэг хүнийг эзэн хэмээн явсан газар үгүй хэмээмүй. Энэ Далай бэг хэмээгч угаас Энэтхэг, Балба, Түвд, Оросын зэрэг орноор хэрэн явж эзэнгүй дураараа худалдаа хийж явсан хүн. Эдүгээ түүний хэлсэн газарт энэ зэрэг учир байв хэмээсэн тул энэ хэргийг хэрхэн болгохыг Их журганаас заасныг үзэж дагаж явъя хэмээсэн буй. Байцааваас, урьд Эфүгийн газраас түүний харьяат хотон Далай бэгийг эдүгээ Жавзандамба хутагтын шавь нартай хамт суусан буй. Журганаас хэрхэн болгох газрыг тогтоож өгнө үү хэмээн өргөн барьж хүргэн ирүүлснийг бидний журганаас хотон Далай бэг угаас хэрхэн шавь нартай хамт суусан, эдүгээ тэнд байх эсэх газрыг байцааж мэдүүлэн эрүүлье хэмээн Шанзудбад байцаахаар одох бичиг илгээснийг дансанд тэмдэглэсэн буй. Эдүгээ Шанзудбагийн газраас байцааж өргөн барьсан газарт, Далай бэг хэмээгч угаас Энэтхэг, Балба, Түвд, Оросын зэрэг оронд худалдаа хийж явах хүн.

Угтаа Өөлдийн хотон биш тул хэрхэн буулгах газрыг журганаас зааж өгнө үү хэмээсэн буй. Далай бэг эсвээс эфү Абуугийн харьяат хотон мөн бусад газрыг тодорхойлон байцаахгүй болбоос туг тугаараа хэлэлцэж болохгүй тул үүнийг эфү байсан Абуугийн хошуунд бичиг илгээж хотон Далай бэг эхэндээ

хэрхэн эфү (хоосон зай) харьяат болсон үнэн тэмдгийг тодорхойлон гаргаж мэдүүлэн ирүүлье. Хүрч ирсэн цагт дахин хэлэлцье. Үүний тул илгээв. Тэнгэрийн тэтгэсний дөрөвдүгээр оны арван сарын хорин наймнаа.

1. Бичгийн агуулгыг задлан шинжихүй

Тус манж данс бол Дайчин гүрний (dai qing, 大清) Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яамнаас Алшаагийн хошууд хошууны тамгын газарт явуулсан бичиг болно. Бичгийн огноо нь Тэнгэрийн тэтгэсний дөрөвдүгээр оны арван сарын хорин найман буюу нийтийн тоололын 1739 оны 11 сарын 28-ны өдөр байна.

Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам бол Дайчин гүрний хааны захиргаан дахь монголчуудын хэрэг явдлыг хүлээн шийтгэх яам билээ. Тус яам Дээд эрдэмтийн анхдугаар он буюу 1636 онд байгуулагджээ. Их төлөв монголчуудтай хамаатай хэргийг шийтгэх тул бас Монгол журган хэмээдэг. Хожим монгол, хятадын зах хязгаар нийлэх газрын хэргийг шийтгэхийн тулд Улаанхад, Яргай, Гурван суварга зэрэг газарт тусгай занги томилон суулгаж, “... газарт сууж монгол, хятадын хэргийг шийтгэх журганы занги” байгуулсан болохоор монголчууд Бээжингийн яамыг Их журган хэмээн дуудах болов. Бас Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсний үед Дайчин гүрнээс монголын дотоод дахь самуурлыг далимдуулан баруунш нутгаа өргөтгөж, угтаа монголын харьяат байсан Хөхнуур, Төвд, Уйгар, Хасаг зэрэг улс үндэстний газрыг эрхшээлдээ оруулж, Манжийн хааны эзэмшил нутаг болгов. Монголчуудтай өрсөлдөж тэмцэлдэж байж олсон газар орон тул дээр дурдсан эдгээр газрын хэргийг мөн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам эрхлэн хариуцах болов. Энэхүү яамнаас монголд явуулдаг албан бичгийн ихэнх нь монголоор, заримдаа манж бичиг хавсаргадаг. Харин Түвдэд бол түвд болон манж, монгол бичиг хавсарган явуулдаг. Үүнээс гадна Оростой бас монголоор дамжиж харилцаж ирсэн болохоор Энх-Амгалан хааны үе буюу 1662 оноос эхлэн Оростой харьцах явдлыг мөн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам эрхлэн даах болов. 1861 онд Гадаад улсын хэргийг бүгд шийтгэх яам байгуулагдах болтол ийм байв. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яам өөр бусад яамтай адилгүй. Тэр нь Дайчин гүрний хаан ба монгол, түвдийн ноёд, лам нарын харилцаанд зуучлах үүрэг бүхий тул Дайчин гүрний монгол төрийн онцлогийг тууштай сайхан тусгаж байдаг юм. Монголын ноёдууд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яаманд захирагдахгүй, хааны зарлигийг л хүлээдэг тул тийнхүү тус яам нь хаан ба монгол ноёдын хооронд ажиллаж байв.

Алшаагийн хошууд хошуу гэдэг нь Ойрад монголын нэгэн аймгаас бүрэлдсэн засгийн хошуу билээ. Ноёд нь Хавт хасарын хойчис. Уг нь Халх, Ойрадын төрд байв. 1677 онд Ил Тарвагатайн газарт байсан ойрад монголын

дотоодод эвдрэл үүсч, Зүүнгарын Галдан хунтайж өөрийн хадам аав хошуудын Очирт цэцэн хааныг дайран довтолж мөхөөсөнд, Очирт цэцэн хааны харьяанд байсан хошуудын Баатар эрх жонон Хорулай Галдангаас зайлан зүүнш дутаан явж, Хөхнуурт нутаг олсонгүйд аргагүй одоогийн Өвөр Монголын хамаг баруун захын Алшаа уулын баруунтаа ирж, хятадыг үймүүлэв. Үүнд, Дайчин гүрний Энх-Амгалан хаан урд хожид 20 жилийн цаг зарцуулж байгаад Хөхнуурын хошуудын Далай баатар тайж, Зүүнгарын Галдан бошогт, тавдугаар дүрийн Далай лам зэрэг холбогдох хүмүүстэй олон удаа харьцсаны эцэст, Зуунмодны дайны дараа 1697 онд Баатар эрх жонон Хорулайн харьяатыг хошуу сум байгуулан, эзэмшилдээ оруулж чадав. Алшаагийн хошууд хошууны ноёд Хөхнуурын хошуудтай элгэн садан, бүгд Гүүш хааны хойч болно. Бас Очирт цэцэн хааны үеэс Далай ламтай нягт харьцаатай байв. Энэхүү Алшаа нутаг нь даруй тавдугаар дүрийн Далай лам хийгээд Энх-Амгалан хаан хамтаар элч илгээж, зааж өгсөн нутаг билээ. Бас нөгөө талаар Алшаагийн хошууд нь халхын Түшээт хан аймагтай худураг билээ. Очирт цэцэн хааны хөвгүүн Лувзангомборавдан хийгээд Түшээт хан Чахундоржтой Алшаа хошууны хоёрдах засгийн ноён Абуу хийгээд хожмын Сайн ноён аймгийн эфү ноён Цэрэнтэй хоорондоо худураг бололцсон байв. Мөн Алшаагийн хошууд хошууны ардууд Зүүнгарын учрыг сайн мэддэгээс болж Дайчин гүрэнд дагаж орсноос хойш олон удаагийн дайн тулаанд манлай болон томилогдож байв. Тухайлбал, 1696 оны Зуунмодны дайн, 1715 оны Хамийн байлдаан, 1720 оны Түвдэд Зүүнгарын цэргийг үлдэн явуулахаар мордсон дайн, 1755 оны Зүүнгарыг түвшитгэсэн дайн зэрэгт бүр алшаа цэрэг эрс оролцсон байдаг. 1725 онд Найралт төв хаан Лувзанданжины бослогын дараа Хөхнуурын хошуудыг сэргийлэхийн тулд засгийн ноён Абуугийн алшаагийн хошуудыг Хөхнуурын Бор цөнд нүүлгэв. Гэвч удалгүй Зүүнгартай хийсэн дайны дараа 1732 ондуг Алшаа нутагт буцаав¹. Тус манж дансын албан бичгийг явуулсан 1739 оны 11 сард Абуу ноён өөрийн Алшаа нутагт өвчнөөр нас баржээ. Тийм болохоор тус албан бичигт, “Өөлдийн жүн ван байсан эфү Абуугийн хошуунд илгээв” гэж бичжээ.

Хөхнуурын хошууд гэдэг нь ойрад монголын нэгэн аймаг билээ. Ноёд нь адилхан Хавт хасарын хойчис. Халх, Ойрадын төрийн гол улсын нэг байв. 1636 онд Ил Тарвагатайн газарт байсан хошуудын ноён, гүүш цолтой Төрбайх цэргээ авч, Зүүнгарын Баатар хунтайжийн цэрэгтэй хамт өмнөш мордож, Хөхнуурын газарт байсан халхын Цогт хунтайжийн цэргийг ялж, Хөхнуурын газрыг эзлэн авав. 1637 онд гүүш Төрбайх биеэр түвдийн Лхаст очиж тавдугаар дүрийн Далай ламаас “шажныг баригч номын хаан” цол авч, түүнээс хойш Гүүш хаан хэмээгдэх болов. Хожим Гүүш хаан цэргээ дайчлан Амдо, Кам, Үй, Зан зэрэг бүх түвдийг эзлэн авав. 1642 онд Гүүш хан Их монгол улсын Хубилай сэцэн

¹ Энэ тухай дэлгэрэнгүйг, миний “Дайчин гүрний үеийн монголын төр ба нийгэм: Алшаагийн хошуудын түүхийн судалгаа” (齐光, 大清帝国时期蒙古的政治与社会 - 以阿拉善和硕特部研究为中心), Фүдан их сургуулийн хэвлэлийн хороо, 2013-оос лавлана уу.

хаан сакъяагийн Пагва ламд арван гурван түмэн өрх түвдийн ардыг өглөг өгч захируулсан монголын төрийн уламжлалаар Үй, Зангийн газрыг тавдугаар дүрийн Далай ламд өглөг болгож өгөв. Гүүш хан бас монголын нийгэм отог, зайсангийн дүрмийг дагаж, Далай ламд сайд, түшмэд дараалуулан өгч, нутгийн дарга томилон үүгээр суурь болгож Үй, Зангийн газарт Далай ламын засгийн газар байгуулан өгчээ. Энэ засгийн газар монголын маш олон төр засгийн уламжлал, хууль цааз, эзэн албатын ёсоор хэрэг шийтгэж тогтоож байсан билээ. Энэ тухай одоогийн Түвдийн архивт хадгалагдаж байгаа монгол, түвд данс нээлттэй болсоны дараа улам тодорхой болно. Гүүш хаан бас Хөхнуур, Хамийн газрыг өөрийн үр ач нартаа өмч болгон хуваан өгч захируулав. Ингэж 1724 онд Лувсанданжины бослого Дайчин гүрэнд дарагдах хүртэл Гүүш хааны хөвгүүд ноёрхож байсан Хөхнуурын хошууднь Далай ламын засгийн газрыг хамгаалан суухын зэрэгцээ Дайчин гүрний баруун хязгаар орныг сүрдүүлэхүйц их хүчтэй байв. Түүгээр барахгүй, нэн чухал нь Халх-Ойрадын төрд багтах Халхын гурван аймаг ба Зүүнгарын ноёд, сайд, элч нар Лхас орж Далай ламтай уулзаж хэрэг зөвдөхөд тус хийж, замын улаа шүүс өгч, ер хүч хавсарч байв. Ганц жишээ дурдвал, 1640 онд Халх, Ойрадын төр байгуулахад Гүүш хаан болон Засагт хааны гавьяа хамаг их буй. Тэгээд 1724 онд Дайчин гүрний Лувсанданжины бослогоос үлдэж хоцорсон Хөхнуурын хошуудыг хошуу сум байгуулж, өөрийн эрхшээлдээ оруулав. Түүнээс эхлэн сүр нь буурч, хүч нь муудав. Хожим нь Хатан голын өмнө байсан түвдхулгай нар голын хойно гарч тэднийг ихэд зовоожээ.

Эд нарын хойчис одоо Хөхнуур мужийн Дэлхий хот, Голомт хот, Улаан сиань, Дулаан сиань хийгээд Цайдамын газарт төвлөрөн сууж байна. Үүнээс гадна түвдийн Нагцын газарт бас цөөн тооны хүмүүс байдаг.

Мэргэн дайчин Эринчин хэмээгч Гүүш хааны хоёрдугаар хөвгүүн Омбо хунтайжийн ахмад хөвгүүн Мэргэн тайжийн хоёрдугаар хөвгүүн билээ. Түүний нутаг нь Хөхнуурын хойно, цахарын Лигдэн хаан нас барсан Шар талд ойрхон байдаг. Мэргэн дайчин Эринчиний эцэг мэргэн тайж Сүбэ нь Дайчин гүрэнтэй Шар талын газрыг булаалдаж байсан тэмдэглэл олон буй. Тус манж бичгээс үзэхэд, Мэргэн дайчин Эринчин нэгэн үе Цагаан хэрэм гатлан, Хөндлөн гол даруй одоогийн Эзнээ голын урсгал дагуу газарт нүүн ирж сууж байжээ. Тухайн үед Дайчин гүрний Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсний хааны эхэн үед Хөндлөн голын газрыг Алшаагийн хошуудын ноён эзэлж байв. Торгууд нар голдуу Сог нуур, Сов нуурын умард хэсэг Халхтай зах нийлж байгаа газарт байсан бөгөөд Алшаагийн хошууд хошууны ноён торгууд хошууг хамжин захирч байв. Үүнд, Алшаагийн хошууд хошуу ноён Абуу болон Хөхнуурын хошуудын ноён Мэргэн дайчин Эринчин хоёр мэдээж Гүүш хааны үр хойч болохоор харилцан “ойр төрлийн ахан дүү” нар байсан билээ. Чухам тийм учраас Мэргэн дайчин Эринчин даруй Цагаан хэрэм гатлан Абуугийн харьяат Хөндлөн голын газарт

нүүн очиж, нэгэн үе сууж чадсан бололтой.

Хотон Далай бэг хэмээгчийн тухайд, гагц энэхүү манж дансны агуулгаас үзэхэд түүний яс нь Да сиань аж. Да сиань гэдэг нь одоогийн БНХАУ-ын Ганьсу муж, Хөхнуур мужид байгаа Дунсянь үндэстэн болно. Тэд нар голдуу одоогийн Ганьсумужийн Линся нутагт төвлөрөн суух ба Өөртөө засах сиань болно. Тэд нар өөрийгөө “сарт” хэмээн нэрлэх тул Чингис хааны монгол цэрэгт олзлогдсон Төв азийн сартуул иргэний хойч нар байх нь гарцаагүй. Тангуд, Хятадыг дайлахын тулд нааш авч ирсэн бололтой. Бас бидний мэдэхчилэн, дунсянь нарын хэл нь алтай язгуурын хэл бөгөөд монгол хэлний бүлэгт багтдаг. Гэвч ондоо зүйл нь тэд исламын шашинтай. Тийм болохоор бас Дунсянь хотон хэмээн нэрлэдэг. Арилжаа худалдаа хийхдээ маш гарамгай болно. Харин Далай бэг гэсэн энэ хоёр үг бүр монгол үг бөгөөд бараг түүний эзнээс хайрласан цол байж мэднэ. Хөхнуурын хошуудын ноён Мэргэн дайчин Эринчин Алшаагийн хошууны ноён Абууд, “чи тэр хотонг хоморгож ав” хэмээснээс үзэхэд Далай бэг уг нь Мэргэн дайчин Эринчиний албат байсан нь лавтай. Тийм бус бол зүв зүгээр харийн хүнийг Абууд “чи очиж ав” хэмээн хэлж үл чадах бөгөөд монголын эзэн албатын ёсонд ч нийцэхгүй билээ. Энэ Далай бэг Гүүш хаан хийгээд түүний хөвгүүд Хөхнуур, Хамиг эзлэн авахад орж өгч, албат өгсөн хүний хойч үр үү. Эсвэл 1649 онд Мэргэн дайчин Эринчий эцэг Мэргэн тайж Дайчин гүрэнтэй хүч хавсран Ганьсумужид гарсан Дунсяний үндэстэний Миляний урвалгыг дарах үед олзолсон хүний хойч үр үү. Аль нь ч байж мэднэ. Энэ монгол ноёны албат хотон Далай бэгийн өчсөн зүйлээс, бид тэр үеийн монгол ноёдын доорх худалдаачид хэрхэн худалдаа наймаа хийж байсныг мэдэж чадна. Доор бид даруй хотон Далай бэгийн явж өнгөрсөн улс орны байдал ба таньж уулзсан хүмүүсийн тухай шинжиж үзье.

Оросын цагаан хаан. Бид бүхэн Орос гэдэг угтаа европын нэгэн жижиг үндэстэн байсныг мэдэх билээ. XIII зуунд монголын Бат ноёны байлдан дагуулж, Алтан ордын хааны эзэмшил дор оров. Монголын хаан, ноён, хатан нарталба барьж, гааль тушааж байсан оросын олон жижиг улсын дотроос хожим нь Москва улс, Монголын төр засгийн ёс нөлөөгөөр аажмаар хүчирхэгжин мандаж, эргэн тойрны газар орныг нэгтгэсний дүнд том гүрэн болж хөгжиж чадсан бөгөөд 1480 онд Монгол хааны эрхшээлээс мултарч тусгаарлав. Удалгүй 1580 онд Ермак хэмээх хасаг хүн дайчин нөхдөө дагуулан Оросын цагаан хааны дэмжлэгээр Урал уулыг давж, зүүнш түрэмгийлж эхлэв. XVII зууны эхэн болоход оросууд Тобольскоор төв болгон өмнөш, зүүнш түрж байв. Гэвч тэр үеийн оросууд хэдий Сибирийн ой тайгад байгаа гөрөөчин үндэстнийг дайлан дагуулж чадсан боловч Халх, Ойрадын төрийн Зүүнгар, жич Засагт хааны аймаг шиг монголын аймаг улсад эс халдаж чадав. Тийм учраас цэргийн хүчээр авах бодлогоо өөрчилж, Халх, Ойрадын дотоод дахь зөрчлийг ашиглан аргадаж байгаад Оросын цагаан хаанд мөргүүлэн оруулах бодлого хэрэгжүүлжээ. Оросын эрдэмтэн Шастина-гийн “XVII зууны үеийн

Орос, Монголын гадаад харилцаа² хэмээх бүтээлд, Оросын элч нар хэдхэдэн удаа Халх монголын Засагт хаан аймгийн Алтан хааныг Оросын цагаан хаанд мөргөж орж өгөхөөр тангараглахыг ятгасан боловч Алтан хаан ер орж өгсөнгүй болохыг дурдсан буй. Харин 1620 оны үед Алтан хаан Москвад хэдэн удаа элч явуулан, эрх тэгшээр найрсаг харилцааг зорьсон байна. XVII зууны турш монголчууд, Оростой эрх тэгшээр маш олон удаа харилцаж байв. Үүний дотор, 1620 оны үед баруунш Ижил мөрний газарт нүүн очиж суусан торгуудын хэрэг учир нь Монгол ба Оросын хоорон дахь хамгийн том асуудлын нэг байв. Торгуудууд баруунш нүүсэн боловч Халх, Ойрадын олон аймаг улс ба Далай ламын засгийн газартай хэвээр харилцаж байв. 1640 оны Халх, Ойрадын чуулганд торгуудын ноён Хоо Өрлөг мөн оролцож байв. Торгууд улс Ижилд байгаа боловч Халх, Ойрадын төрийн нэгэн гишүүн байсан болохоор ураг, холбоо арилжаа, шашин өглөг зэрэг асуудлаас уг монгол нутгийнхантайгаа нягт харьцаатай байв. Нөгөө талаар, Торгууд улс Оросын цагаан хааны эрхшээлд байгаа олон улс үндэстэнтэй мөн нягт харьцаж байв. Тийм болохоор Хөхнуурын хошуудын ноёны доорх хотон Далай бэг Торгууд улсаар дамжиж, Оросын цагаан хааны газарт худалдаа хийж явсан бололтой. Тухайн үед Орос гүрний төрийг барьж байсан нь алдарт нэгдүгээр Петр байв. Тэрбээр олон талын өөрчлөлт хийж, Оросыг тариалангийн улсаас аж үйлдвэр, арилжаа худалдаа хөгжсөн баруун европын улс шиг болгохоор зүтгэж байв.

Хүнхэр хаан. Монгол, манжийн хүнхэр гэдэг үг перс хэлний *kh k* хэмээх үгнээс гаралтай, хүн алагч, сэмээр алагч гэсэн утгатай гэгддэг Хойно түркийн Османы эзэнт гүрнийг заах болов. Энэ үг бараг баруун хасаг буюу бухарын хүмүүсээр дамжиж монголд орж ирсэн байх магад. Дайчин гүрний Тэнгэрийн тэтгэсний үеийн манж дансанд тухайн үеийн хасагууд өөрийн гарлаа Хүнхэр улсаас гаралтай хэмээж байв³. Тус бичигт гарах Хүнхэр хаан гэдэг нь их төлөв XVII, XVIII зууны үеийн Османы эзэнт улсын хааныг зааж буй. XVII зуунд Ижилийн торгуудууд Оросын цагаан хааны зарлигийг хүндэтгэж, Осман хаант улстай Крымиин хойгийг булаалдаж олон удаа дайн хийж байв. Тиймээс монголчууд түүний тухай сайн мэдэж байсан бөгөөд Шастины судалгаанаас үзвэл, 1637 онд Халх монголын Алтан хаан өөрийн элчээ Москвагаар дамжуулан түркийн султанд томилж байсан удаа ч буй. Алтан хаан Түркийн султан болон Улаантолгойт хаантай худалдааны харьцаа тогтоохоор барахгүй бас чадах чинээгээр гадаад харилцаа тогтоохыг зорьж байсан гэдэг. Үүнээс үзэхэд, XVII зууны монголчууд нэгэнт Османы эзэнт гүрэнтэй элчин худалдааны харилцаатай байжээ. Хотон Далай бэг монгол ноёны албат байсан бөгөөд исламын шашинтай тул Османы эзэнт гүрэнд

² Бээжингийн Багшийн их сургуулийн багш нар хятад хэлнээ орчуулав, Шан-о хэвлэлийн газар, 1977.

³ БНХАУ-ын Төв архив ба Казахстан улсын Дорно дахины судлалын газар хамтран найруулсан *Дайчин гүрний үеийн хятад, хасагийн харилцааны дансын эмхтгэл*, Хятадын Тангийн хэвлэлийн хороо, 2006.

очиж худалдаа хийж байжээ. Тухайн үед Османы эзэнт гүрний дотоододкэпүлүлүг овгийн хүмүүс үе залгамжлан их Бич, даруй их зайсан сууж шударга ажиллаж байсан болохоор улсын хүч нь чанга байсан бөгөөдарилжаа худалдаа маш хөгжиж байв. Османы эзэнт гүрний нутаг болбаас эртнээс нааш ази, европыг хөндлөн холбох чухал газар бөгөөд далайн гарам сайтай, газарзүйн давуу талтай болохоор арилжаа худалдаа хөгжсөөр ирсэн байна.

Гасалбаш хаан. Гасалбаш гэдэг нь эртний Азербайжаныг зааж буй. Гасалбаш гэдэг нь одоогийн Иран, Азербайжан, Афганистаныг ноёрхож байсан азербайжан гаралтай хүний 1501 онд байгуулсан Сафавидулсын хааныг зааж байна. Түшмэд цэрэг нь улаан алчуураар толгойгоо ороодог болохоор улаан толгойт ч гэдэг. 1638 онд Османы эзэнт гүрэн болон Сафавидын эзэнт гүрэн хоорондын дайныг зогсоож, найрамдлын гэрээ байгуулжээ. Түүнээс хойш Сафавид нь Орос болоод Түрктэй угийн худалдааны харьцаагаа сэргээж хэлэв. Тухайн үед Сафавид эзэнтгүрэн арилжаа худалдааг маш чухалчилж, тусгай төрийн бодлогоор хөгжүүлж байв. Нийслэл Ишпахан хотод дэлхийн олон орны худалдаачин хүмүүс цугларч байсан билээ. Дээр дурдсан Алтан хааны элчийн хэлж байсан Улаантолгойт хаан гэдэг нь даруй энэ Гасалбаш хаан болно. 1736 онд Сафи эзэнт гүрний төрийг залгамжилсан туркмен хүний байгуулсан Афшар хаант улсыг мөн Улаантолгойт хэмээн нэрлэж байв.

Энэтхэгийн очирт газар. Могол эзэнт гүрний баруун хойт Гүжарат аймгийг зааж буй. Эртний Хүннүгийн гүжэр аймгийн хүмүүс энд ирж суусан болохоор тийн нэрлэх болов гэдэг. Орчин үеийн энэтхэгийн төрийн богд Ганди даруй энэ газарт мэндлэв. XVII зууны үеийн хүчирхэг орон бол Могол хаантулсын арилжаа худалдаа хамаг хөгжсөн газар билээ. Энд энд голдуу исламын шүтээнтэй мусалманьчууд сууж байдаг. Исламын соёл маш хөгжив. XVII зууны сүүл хагаст Могол хаант гүрний хаан төрийг барьж байсан нь алдарт Ауранзэб (Aurangzeb) байв. Тэр нутаг дэвсгэрээ өргөтгөн, засаг хуулийг чангатган, исламын шашныг мандуулан, арилжаа худалдааг ахиулж байв. Энэ үед Моголын хаант гүрэн хамаг хүчтэй байж нийгмийн эл тал бүр цэцэглэн хөгжиж байв. Тийм болохоор ислам шүтээнтэй хотон Далай бэг Гасалбаш хааны газраас энэ хүчирхэг оронд ирсэн бололтой.

Балба. Даруй бидний сайн мэддэг одоогийн Непал улс. Балбууд Түвдтэй сайн харилцаатай байв. Түвдээр дамжиж монголд балбын дархан нар ирж байсан билээ.

Түвд. Энд голдуу Далай ламын засгийн газрын харьяат Үй, Зангийн орныг зааж буй. 1642 онд Гүүш хаан өглөг өгч, Далай ламын засгийн газрыг байгуулж өгөөдудалгүй 1655 онд нас баржээ. Түүний дараа ахмад хөвгүүн Даян хаан, түүний хөвгүүн Далай хаан, түүний хөвгүүн Лхавзан хаан үе залгамжлан хаан сууж, Далай

ламын амрыг хамгаалан шарын шашныг тэтгэв. Үүний хажуугаар Хөхнуурын хошуудын Далай баатар хун тайж, түүний дараа Даш баатар тайж, түүний дараа хөвгүүн Лувсанданжин аймаг, улсыг эзэн мэдэн залгав. Тэр үед Халх, Ойрадын төрийн аймаг улсууд бүр монголын ёсоор боссон Далай ламын төр шашны эрхийг шүтэж байсан болохоор Лхаст олон монголчууд байсан бөгөөд олон газрын худалдаачид их олон байжээ. Ялангуяа исламын шашинтай худалдаачид Энэтхэг, Иран, Кашмир, Төв азиас бүлгээр энд ирж худалдаа хийж байв. Энэхүү байдал 1950 оны үе болтол үргэлжилж байв.

Шаннан Дорж лам. Хөх хотын Ширээт зуугийн засаг да лам. Энх-Амгалан хааны унаган боол. Багаасаа хаантай хамт Бор хотонд өссөн. Энэ нь Хөх хотын түмэд аймаг Дайчин гүрний хааны албат байсантай холбогдоно. Хожим хааны зарлигаар лам болж, Да ламын тушаалд томилогдсон. 1690 оны үеэр Зүүнгарын Галдан бошогттой дайтаж байх үед Энх-Амгалан хаан Шаннандорж ламыг Галдан ба Халхын ноёд руу илгээж байв. 1696 оны Зуунмодны тулааны дараа түүнийг Сэлэн буюу Шининд томилон суулгаж, Хөхнуурын хошуудын ноёдыг аргадан татахын хажуугаар Зүүнгар ба Далай ламын хоорондын мэдээ зангийг сэмээр олж, хаанд өргөн мэдүүлж байв. Шаннандоржийн тухай японы судлаач Ё.Күсиноки сайтар судалсан буй. Шаннандорж ламын тухай манж данс БНХАУ-ын Нэгдүгээр Түүхийн архивт хадгалагдаж байна.

Хиа Ананд. Өми овогтой. Бээжингийн найман хошууны шулуун шарын монгол хошууны хүн. Өвөг нь цахарын Лигдэн хааны их зайсан байсан Балайдур магнай бөлгөө. 1634 онд 230 өрх харьяат ардаа дагуулж, манжийн хаан Хунтайжид даган орсонд хааны харьяат шулуун шарын хошуунд оруулав. Ананд өвөг эцгийн цэргийн гавьяагаар хааны хиа болж, хишиг хүртэв. 1688 онд Галдан бошогт Халхыг довтлох үед ар монголд томилогдон, Галдантай хэрэг ярилцав. 1690 онд Ананд мөн Энх-Амгалан хааны зарлигаар Өвөр Монголд зайлан орж ирсэн халхын ноёд тайжийг идэвхжүүлэн Галдантай дайтхаар бэлтгэв. 1696 оны Зуунмодны байлдааны дараа Баатар эрх жононы доорх алшаагийн цэргийг дайчлан Энээ, Булингарын газарт Галдангийн түвдтэй харилцах замыг хаав. 1697 онд Шаннандорж ламтай хамт Сэлэнд томилогдов. Гэвч тэр хоёр харилцан эв муутай, маргаж хэрэлддэг байв. Ананд 1701 онд уушгины өвчнөөр нас барав. “Өрнө умрыг биеэр төвшитгөн тогтоосон бодлогын бичиг”-т Анандын нэр олон гардаг билээ.

Хиа Хэшт. Бээжингийн найман хошууны шулуун цагаан монгол хошууны хүн. Анандын дарга Сэлэнд томилогдон суусан Энх-Амгалан хааны хиа. Бас Энх-Амгалан хааны элчийн хувиар түүнийг Зүүнгарын хунтайж Цэвээнравдан руу томилж байв.

2. Далай бэгийн худалдаа хийж явсан зам ба тухайн үеийн Монголын байдал

Тус манж дансны агуулгыг хураангуйлбал, дараах мэт. Урьд Алшаагийн хошууны засгийн ноён, төрийн эфү Абуу халхын Жавзундамба хутагтын шавийн хэргийг шийтгэх Эрдэнэ шанзудба Доржванчигт бичиг явуулж, түүний шавь нартай хамт сууж байгаа хотон Далай бэгийг хурааж авсугай хэмээв. Үүнд Шанзудбын газраас, “Энэ Далай бэг эхэндээ эзэнгүй хотон хэмээн хэлж шавь нартай хамт суув. Хэрэв үнэн Абуугийн харьяат бол аваад яв” хэмээсэн авч харин барьж өгье гэсэнгүй. Аймаг хошуу алсалсан хэрэг тул Шанзудбын газраас барьж өгөхийг хүссэн Абуу энэ хэргийг Их журганд мэдүүлж, журганы заасныг дагая хэмээв. Түүний өмнө Найралт төвийн 4 (1726) онд Гадаад Монголын Төрийг засах явдлын яамнаас Абууг Хөхнуурын хошуудын хэргийг хамаагүй хамаарч байна гэсэн шалтгаанаар ял хэлэлцэж, жүн вангийн хэргэмийг бууруулж бэйл болгосон билээ. Тиймээс Абуу ихэд хичээх болсон байна. Тэгээд Абуугийн өргөн барьсан хэргийг мэдсэн Их журганаас, Жавзундамба хутагтын Эрдэнэ Шанзудба Доржванчигт хотон Далай бэг эхэндээ хэрхэн шавь нартай хамт суусан, одоо шавь нартай хамт байгаа эсэхийг тодорхойлж байгаад сая шийтгэе хэмээн бичиг явуулжээ. Эрдэнэ шанзудба Доржванчиг хотон Далай бэгээс учир тухайг нь тодорхойлж, Абуугийн харьяат ч биш, ер хэний ч харьяат бус, олон газраар хэрж худалдаа хийж явсан худалдаачин хүн хэмээх хариуг Их журганд өргөн мэдүүлэв. Үүнд, Их журган Абуугийн хошуунд бичиг явуулж, хотон Далай бэг чухам хэрхэн Абуугийн харьяат болсныг гэрчлэх тэмдэг бичиг байгаа эсэхийг лавлаж энэ бичгийг илгээжээ.

Далай бэг чухам эзэнтэй юу, үгүй юу. Урьд хэрхэн өөрийгөө эзэнгүй хотон хэмээн хэлж Жавзундамба хутагтын шавь болсон тухайд, өмнө дурдсанчлан хотон Далай бэг бол Хөхнуурын хошуудын ноён мэргэн дайчин Эрэнчиний албат харьяат байсан нь үнэн. Тэгэхгүй бол Эрэнчин Абууд найдаж, Далай бэгийг хурааж авах ёсгүй. Тус манж дансанд дурдах Мэргэн дайчин Эрэнчин Хөндлөн голын газарт ирж түр суусан нь Найралт төвийн 2 (1724) оны Лувсанданжины бослогоос өмнө болсон явдал мэт. Учир нь бослогыг дарсны дараа Дайчин гүрэн хошуу сум байгуулж, нутгийн зааг тогтоосон тул Хөхнуурын хошуудын эрх чөлөө хязгаарлагдаж дураараа нүүж шилжихгүй болов. Тиймээс лавтай 1724 оноос өмнөх хэрэг байх ёстой. Тэгвэл Далай бэг яагаад өөрийгөө эзэнгүй хүн гэсэн бэ. Хэрэв эзэнгүй хэмээн хэлэхгүй бол Эрдэнэ Шанзудба түүнийг хутагтын шавь нартай хамт суулгах ёс байхгүй. Үүний тухай Лувсанданжины бослогын дараа Нянь Гэняо хэмээх найман хошууны гаралтай хятад жанжин Найралт төв хаантай зөвдөөд, угтаа Хөхнуурын хошуудын ноёндалба өргөж байсан хотон, түвд, салар, баоань, дунсянь зэрэг хятад, монголын заагт сууж байсан үндэстнийг Дайчин гүрний дотоод ард болгож, Сичуань, Ганьсу хоёр мужийн харьяат эсвэл нутгийн түшмэд (tu shi, 土司)-ийн харьяат болгосон тул Хөхнуурын хошуудын ноёд олон

албатаа алдав. 1724 онд хотон Далай бэг яг ар монгол Халхын газарт худалдаа хийж байв. Худалдаачны мэдээ их хурдан болохоор тэр Хөхнуурт гарсан дээрх хэргийг сонсоод, өөрийн биеэ эзэнгүй гэж ярьсан байж болох. Хотон Далай бэг Энх-Амгалангийн 46 (1707) онд Халхад очсон боловч тэр даруй Жавзундамба хутагтын шавь болсонгүй. Худалдаа хийж байгаад Лувсанданжины бослогын улмаас Хөхнуурын хошуудын эзэнтэйх эзэн харьяатын харьцаа нь Дайчин гүрэнд хүчээр тасалдсаны дараа сая хутагтын шавь болов.

Ийм учраас хотон Далай бэг Эрдэнэ шанзудбаар дамжуулан Их журганд өчсөн үг нь бүр зөв болно. Тиймээс түүний олон газраар хэрж худалдаа хийж явсан нь мөн үнэн болов уу. Хэрэв тэрбээр худал өчсөн бол Их журганаас Ананд, Шаннандорж нарыг гэрийн хүмүүсийг эрж олоод, үнэн эсэхийг олж болох боломжтой билээ. Анандын хөвгүүн Арана, Аранагийн хөвгүүн Омитай нар бүр Манжийн хааны нэртэй хиа, нэртэй сайд болсон бөгөөд найман хошуу, олон монголчуудад нэр алдартай байсан билээ.

Хотон Далай бэгийн өчгийн дагуу түүний худалдаа хийж явсан замыг тодорхойлвол дараах мэт. Юуны өмнө, Хөхнуурын хошуудын ноён Мэргэн дайчин Эринчиний нутгаас мордож, Зүүнгарын Галдан бошогт буюу хунтайж Цэвээнравданы харьяат уйгур, хасаг, бухарын газрыг дайрч, баруунш Ижил мөрний газар торгуудын нутагт очиж, тэндээс Оросын цагаан хааны харьяат газарт одож, улмаар өмнөш бууж түркийн Османы эзэнт гүрэнд хүрч худалдаа хийгээд дахин зүүнш явж Азербайжан, Ираныг ноёрхож байсан Гасалбаш хааны газар хүрч, тэндээс бас зүүнш Энэтхэгийн Гүжират муж, Балбаар дамжин түвдийн Үй, Зангийн газар ирж түүний хойно Хөхнуурт харьж, дараа нь бас Сэлэнээс Бээжин орж, Бээжингээс Хөхнуурт эгэн ирсэн авч дахин Энэтхэгт очоод эргэн Хөхнуураас Хами явж, Хамигаас Халхын нутагт одож худалдаа хийж байгаад хутагтын шавь болж Халхад суужээ.

Хотон Далай бэг эдгээр олон газраар явсан ахуй байдал гэвэл, тухайн үед Халхын гурван аймаг, Хөхнуурын хошууд, Зүүнгар, Ижилийн торгууд, Далай ламын засгийн газар адилхан нэг Халх, Ойрдын төрд байж, 1640 оноос хойш харилцан нягт холбоотой байв. Үүнийг далимдуулан Мэргэн дайчингийн харьяат хотон Далай бэг эзнийхээ зарлигийг хүлээж, орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ олон газрын мэдээ занги олохын тулд ийм олон газраар явжээ. Яг тэр үед Оросын цагаан хаан нэгдүгээр Петр, түркийн Османы эзэнт гүрний Бич, Сафи (Safavid) хаант улсын хаан, жич энэтхэгийн Моголын хаан Ауранзэб нар бүгд арилжаа худалдааг хөгжүүлж байсан бөгөөд Осман, Сафи, Моголын улс нь бүгд исламын шашинтай учраас хотон Далай бэг маш амархнаар олон газарт явж чадсан бололтой. Өөрөө ч явах дуртай байсан магад. Бас Хөхнуурт буцаж ирсэний дараа тухайн үеийн Дайчин гүрэн Хөхнуурын хошуудын ноёдыг чадах

чинээгээр аргадан татаж байсан учраас л хотон Далай бэг мөн Мэргэн дайчины тушаалаар Бээжин орж, Дайчин гүрний мэдээг цуглуулсан хэмээн санана. Ингэж байгаад Мэргэн дайчин Хөндлөн голд очиж суухад хотон Далай бэг ойрхон Хами, Турфанаас Халхад ирсэн байна. Энэ нь тухайн үеийн Хөхнуурын хошуудын ноёд Дайчин гүрний сүрдүүлгээс болж, Зүүнгат “Хөхнуур, Халх нар сэжиглэж элч худалдааг явуулахгүй⁴” болсонтой холбоотой. Чингэж эв эвдэрснээс 1707 онд Цэвээнравдан ч зүүнээс ирсэн худалдаачныг Фижан, Бухын газарт хорин хашиж, Зүүнгарын нутгаас өнгөрөхийг цаазалжээ. Баруунш явж чадахгүй болсноос Мэргэн дайчин хотон Далай бэгийг Халхад томилсон байж магад. Мөн тэр цагаас эхлэн Зүүнгар ба Дайчин гүрний харьцаа дандаа дайсагнаж, худалдаачид чөлөөтэй явж чадахгүй болж, бас 1715 оны Хамийн байлдааны дараа хоёр этгээд дайны байдалд орсноос улам нэвтэрч чадахгүй болов. Ийм учраас хотон Далай бэг ер Халхад байв. Түүнээс хойш Хөхнуурын хошуудын сүр буурч, Дайчин гүрэнд дарагдсан болохоор хотон Далай бэг ер харьсангүй.

Дүгнэлт

Тус өгүүлэгийн шинжилгээгээр дамжиж доорх мэт зүйлийг олж мэдэв.

XVIII зуун хүртэл монголын ноёд өөрийн харьяат худалдаачинтай байж, тэднийг ашиглан сангийн орлогоо нэмэгдүүлж байснаар барахгүй бас тэднээс дэлхийн мэдээг сонсож байв. Тэдний дотор хамгийн нэртэй нь Зүүнгарын бухар худалдаачид билээ.

XVIII зуун, өөрөөр хэлбэл Дайчин гүрэнд дагаж орох хүртэл монголын худалдаачид дэлхийн олон газраар явж, ялангуяа угтаа Монголын эзэнт гүрний харьяанд байсан улс оронтой харьцаатай хэвээр байв. Зөвхөн Хятад, Манж, Түвд төдийгүй ази, европын олон улс үндэстэний мэдээ учрыг сайн мэдэж байв.

Эртний монголын худалдаанд эрх чөлөө ба улсын харилцаа маш чухал байв. Халх, Ойрадын төр маш чөлөөтэй байсан тул хотон Далай бэг мэтийн монгол ноёны худалдаачин дэлхийгээр чөлөөтэй худалдаа хийж байжээ. Хожим нь Дайчин гүрний учраар Зүүнгар, зүүнээс ирсэн худалдаачдыг цаазалсанд баруунш явж эс чадав. Хөхнуураас Халх илүү завшаантай байсан болохоор Халхад худалдаа хийж суусан бөгөөд ноёноо алдсаны дараа шууд хутагтын шавь болж тогтов. Энэ нь дэлхийн худалдааны түүхтэй ч адилхан. Даруй эрх чөлөөтэй газраар худалдаа наймаа хөгжих, эс бол доройтно гэдэг.

Эзэн харьяатын ёс бол эртний монголын нийгмийн гол харьцаа бөгөөд оршин тогтнох батсуурь мөн. Ар, өвөр монголд бүр XX зууны эх болтол баримталж


⁴ Өөлдийн Цэвээнравданд буулгах зарлигийн бичиг, БНХАУ-ын Төв архив ба ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургууль хамтран найруулсан *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс*, Боть 17, 540. Энэ бичгийг Энх-Амгалангийн дөчин наймдугаар оны арван нэгэн сарын арван тавны өдөр хийж дуусгав.

байв. Энэхүү ёсонд суурилан монголын төр засаг, ахуй амьдрал, арилжаа худалдаа, цэргийн байгуулалт бүр эрчимтэй хөгжиж байсан боловч Дайчин гүрэнд эрх чөлөөгөө алдсанаас сөрөг нөлөө үзүүлсэн бололтой. Энэ их чухал асуудал тул сайтар судлах хэрэгтэй.


Монгол бичгээс хөрвүүлсэн Ц.Жамбалдорж, Н.Сүхцээж

Abstract: In this article, content analysis of the Manchu source material that has been kept in the Archive of Alasha Left Banner, Inner Mongolia reveals the travel paths and manner of a Muslim merchant who served under a Mongol lord in Qinghai (Köke nayur) from the mid-17th century to the early 18th century. The article also considers the characteristics of trade in Mongols' territories and the international relations between Eurasian countries by exploring the relationships between Qalq-a and Oyirat that concerned their domestic affairs, and especially the trade relations of the Mongol state of Qalq-a Oyirat with the Da Qing Dynasty, the Imperial Russia, the Ottoman Empire and the Mughal Empire of India during the above periods.

Нэгэн манж дансаас XVII-XVIII зууны
үеийн Монголын худалдаачны тухай өгүүлэх нь



Зураг 1. Дансны нүүр



Зураг 2. Данс